



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 4/208

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 175 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,656,716 (гурван сая зургаан зуун тавин зургаан мянга долоон зуун арван зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 175 дугаар цэцэрлэг (С.Одсүрэн)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 2,539,297 (хоёр сая таван зуун гучин есөн мянга хоёр зуун ерэн долоо) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 2 нэр төрлийн 1,117,419 (нэг сая нэг зуун арван долоон мянга дөрвөн зуун арван ес) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсаны орлогын 30 хувь 12,000 (арван хоёр мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сүхбаатар дүүргийн 175 дугаар цэцэрлэг (С.Одсүрэн)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000627

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 1 дугаар сарын 01-ны өдрийн А/88 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 175-р цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжээ жил	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгуулагын үнийн санал	Мэргэжилтний санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж													
1	Бага оврын кассет болон тоглуулагч	9	ш	1	291,720.00	291,720.00	291,720.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
2	Будаа агшаагч	9	ш	1	100,217.00	100,217.00	100,217.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
3	Тоос сорогч	9	ш	4	109,990.00	439,960.00	439,960.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
4	Тоос сорогч	7	ш	1	166,900.00	166,900.00	166,900.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
5	Хөлдөөгч	9	ш	1	625,421.00	625,421.00	625,421.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	25,000	25,000
6	Цахилгаан махны машин	9	ш	1	491,998.00	491,998.00	491,998.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	15,000	15,000
	Машин, тоног төхөөрөмжийн дүн					2,116,216.00	2,116,216.00	-				40,000	40,000
Тавилга, эд хогшил													
7	Хүүхдийн хувцасны шүүгээ	9	ш	25	61,620.00	1,540,500.00	1,540,500.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
	Тавилга, эд хогшлын дүн					1,540,500.00	1,540,500.00	-					
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн													
	Үүнээс: Худалдах хөрөнгө					1,117,419.00	1,117,419.00	-					
	Устгах хөрөнгө					2,539,297.00	2,539,297.00	-					
	Худалдсанаас олох орлого					40,000							
	НӨАУГ-т төвлөрүүлэх (30%/)					12,000.0							